

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үндэсний Давхар Даатгал ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/73/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: БДО аудит ХХК-ийн Партнер Д. батсуурь Утас:77-404040 Цахим хаяг: batsuuri@bdo.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	13
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.2 Төсвийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандартууд
БДО	Бусад дэлгэрэнгүй орлого
БҮЦӨАА	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайлан бүртгэгдэх
БҮЦӨБДОБ	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх
МИД	Малын индексжүүлсэн даатгал
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББОУСЗ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын олон улсын стандартын зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НХНА	Нэгж хувьцааны ногдол ашиг
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд
Тод	Санхүүгийн тайлангийн тодруулгууд
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/711
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үндэсний давхар даатгал ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Үндэсний давхар даатгал ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Үндэсний Давхар Даатгал ХК нь даатгалын хураамжийн орлогыг СТОУС-17 “Даатгалын гэрээ” стандартын дагуу хэмжин нягтлан бодох бүртгэлд тусгадаг байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Компани нь тайлант жилийн санхүүгийн байдлын тайлангийн өр төлбөрийн хэсэгт багтсан даатгалын гэрээний өр төлбөрт даатгалын гэрээний үүрэг болох даатгалын нөхөн төлбөрийн нөөц санг нийт 13,948.9 сая төгрөгөөр (2024 онд 11,764.9 сая.төгрөг) хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь нийт өр төлбөрийн 97% (2024 онд 96%) хувийг эзэлж байна. Даатгалын нөөц сангийн тооцоолол нь тусгай аргачлал шаардсан нарийн төвөгтэй тооцоолол бөгөөд таамаглал, шийдэлд багахан өөрчлөлт орсноор санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх боломжтой тул бид энэхүү асуудлыг Аудитын гол асуудал гэж тодорхойлсон.

Бид даатгалын нөөц санг үнэлэхдээ дараах аудитын горимуудыг хэрэгжүүлсэн.Үүнд:

- Нөөцийн сангийн тооцоолол болон хүлээн зөвшөөрөлтийг хамрах голлох дотоод хяналтын тогтолцоо, процессыг үнэлж шалгасан;
- Нөөц сангийн тооцоололд ашигласан өгөгдлүүдийн ул үндэстэй байдлыг үнэлсэн; зарим биет горимуудыг гүйцэтгэн шалгасан
- Ажилдаа хөндлөнгийн хараат бус, хангалттай ур чадвар бүхий аудиторын экспертийг ажиллуулж актуар тооцоололд ашигласан аргачлал болон шийдлийн зохистой байдал, арифметик тооцоолол үнэн зөв эсэхийг шинжилгээ, дахин тооцоолол болон зарим биет горимуудыг гүйцэтгэн шалгасан.

Бусад асуудлын хэсэг

“Үндэсний Давхар Даатгал” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангуудад Нексиа Глобал Монголиа Аудит ХХК аудит хийж, “Өөрчлөлтгүй” дүгнэлт илэрхийлсэн байна.

Мөн бид 2025 оны аудитын нэг хэсэг болгон энэхүү тайлангийн тэмдэглэл 28 зэрэгцүүлэгдэх мэдээлэлд тусгасан 2024 оны санхүүгийн тайланд хийсэн дахин ангиллын залруулгыг аудит хийсэн ба бидний дүгнэлтээр эдгээр залруулгууд нь зохистой бөгөөд үнэн зөв хийгдсэн байна. Бид дээрх залруулгуудаас бусад зүйлсийн хувьд компанийн 2024 оны санхүүгийн тайланд аудит, хяналт болон ямар нэгэн горим хэрэгжүүлэхээр тохироогүй тул 2024 оны санхүүгийн тайланд бүхэлд нь ямар нэг баталгаа гаргах эсвэл санал дүгнэлт илэрхийлээгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,630,703,376.24	1,332,398,408.40
1.1.2	Дансны авлага	1,103,424,925.60	1,448,401,568.97
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	
1.1.4	Бусад авлага	388,800.00	2,164,661.35
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	57,967,998,961.45	62,618,442,958.83
1.1.6	Бараа материал	18,882,376.00	46,442,307.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	1,416,433,084.77	1,810,627,853.93
1.1.8	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	55,079.55
1.1.9	Эргэлтийн хөрөнгийн дүн	62,137,831,524.06	67,258,532,838.03
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	201,788,112.42	547,882,512.19
1.2.2	Биет бус хөрөнгө	5,054,133.36	1,263,533.40
1.2.3	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	206,842,245.78	549,146,045.59
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	62,344,673,769.84	67,807,678,883.62
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Санхүүгийн түрээсийн өр төлбөр	-	408,897,014.10
2.1.2	Дансны өглөг	27,992,288.95	34,373,660.30
2.1.3	Татварын өр	410,855,300.00	-
2.1.4	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.5	Богино хугацаат өр төлбөрийн дүн	438,847,588.95	443,270,674.40
2.2.1	Урт хугацаат өр төлбөр	12,937,648,710.64	15,589,146,549.61
2.2.2	Хойшлогдсон татварын өр	20,892,913.62	30,160,501.35
2.2.3	Урт хугацаат өр төлбөрийн дүн	12,958,541,624.26	15,619,307,050.96
2.2	Өр төлбөрийн нийт дүн	13,397,389,213.21	16,062,577,725.36
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	24,500,000,000.00	24,500,000,000.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Тогтвортой байдлын нөөц сан	19,000,000,000.00	19,000,000,000.00
2.3.5	Эздийн өмчийн бусад хэсэг	4,186,962,126.11	4,186,962,126.11
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	
2.3.7	Хуримтлагдсан ашиг	1,260,322,430.52	4,058,139,032.15
2.3.8	Тайлант үеийн ашиг	-	
2.3.9	Эздийн өмчийн дүн	48,947,284,556.63	51,745,101,158.26
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	62,344,673,769.84	67,807,678,883.62

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	7,697,693,946.35	11,413,707,508.30
2	Борлуулалтын өртөг	(8,943,412,956.16)	(9,632,259,302.78)
3	Нийт ашиг (алдагдал)	(1,245,719,009.81)	1,781,448,205.52
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлог	-	-
8	Бусад орлого	8,626,515,020.87	8,677,983,869.35
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(4,803,675,879.51)	(5,964,552,846.30)
11	Санхүүгийн зардал	(587,221.24)	-
12	Бусад зардал	(599,736,981.87)	(263,703,769.67)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Татварын өмнөх ашиг (алдагдал)	1,976,795,928.44	4,231,175,458.90
16	Орлогын татварын зардал	(845,071,102.39)	(867,496,357.25)
17	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
18	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,131,724,826.05	3,363,679,101.65
19	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
19.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
19.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
19.3	Бусад олз (гарз)	-	-
20	Орлогын нийт дүн	1,131,724,826.05	3,363,679,101.65

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Тогтвортой байдлын нөөц сан	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	24,500,000,000.00	19,000,000,000.00	489,264,426.00	5,882,684,894.38	49,871,949,320.38
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(254,087,289.91)	(254,087,289.91)
3	Залруулсан үлдэгдэл	24,500,000,000.00	19,000,000,000.00	489,264,426.00	5,628,597,604.47	49,617,862,030.47
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,131,724,826.05	1,131,724,826.05
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	3,697,697,700.11	-	3,697,697,700.11
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	(5,500,000,000.00)	(5,500,000,000.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	24,500,000,000.00	19,000,000,000.00	4,186,962,126.11	1,260,322,430.52	48,947,284,556.63
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	3,363,679,101.6	3,363,679,101.65
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	(565,862,500.00)	(565,862,500.00)
16	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	24,500,000,000.00	19,000,000,000.00	4,186,962,126.11	4,058,139,032.15	51,745,101,158.

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	19,131,163,964.22	13,254,091,758.56
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,652,958,588.99	8,893,796,503.50
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан орлого	10,359,706,216.64	-
1.1.4	Бусад мөнгөн орлого	3,118,499,158.59	4,360,295,255.06
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(23,733,882,695.00)	(16,606,781,058.37)
1.2.1	Ажиллагсдад олгосон мөнгө	(2,019,220,968.75)	(2,671,670,488.42)
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад олгосон мөнгө	(573,039,265.82)	(708,502,763.16)
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	(6,361,900.00)	(3,094,000.00)
1.2.4	Нөхөн төлбөрт төлсөн	-	(3,117,760,917.6)
1.2.5	Шатахуун, тээврийн зардалд төлсөн мөнгө	(46,455,660.00)	(40,734,088.14)
1.2.6	Татварын байгууллагад төлсөн мөнгө	(1,062,612,950.94)	(1,608,915,396.86)
1.2.7	Даатгалын байгууллагад төлсөн мөнгө	(3,620,320,722.32)	(4,110,795,397.52)
1.2.8	Бусад мөнгөн зарлага	(16,405,871,227.17)	(4,345,308,006.69)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,602,718,730.78)	(3,352,689,299.81)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,593,816,928.74	8,582,838,706.57
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Хүлээн авсан хүүгийн орлого	8,593,816,928.74	8,582,838,706.57
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(2,452,558,750.00)	(9,371,630,985.41)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(142,612,550.00)	(84,793,040.00)
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(9,946,200.00)	
2.2.3	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	(2,300,000,000.00)	(9,286,837,945.41)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,141,258,178.74 3	(788,792,278.84)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	4,731,539,110.81
3.1.1	Бусад	-	4,731,539,110.81
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(1,391,587,000.00)	(888,362,500.00)
3.2.1	Төлсөн ногдол ашиг	(1,391,517,000.00)	(565,862,500.00)
3.2.2	Бусад мөнгөн зарлага	(70,000.00)	(65,147,040.65)
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	(257,352,959.35)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,391,587,000.00)	3,843,176,610.81
4	Гадаад валютын зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	146,952,447.96	(298,304,967.84)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,483,750,928.28	1,630,703,376.24
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,630,703,376.24	1,332,398,408.40

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024	2025		Харьцуулалт			
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/2025 гүйц	Хувь	2025 төл/2025 гүйцэт	Хувь
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:	м.төг	24,970,853.5	8,705,655.3	20,189,605.1	3,808,958.6	80.8	1,483,949.8	107.9
1	Нийт даатгалын хураамж (дээд, дунд түвшин)	м.төг	7,697,693.9	11,215,316.1	11,413,707.5	3,716,013.5	148.3	198,391.4	101.7
	Хөрөнгө оруулалт, үндсэн үйл ажиллагааны орлого	м.төг	8,585,038.7	7,253,378.4	8,677,983.8	92,945.1	101.0	1,424,605.4	119.6
	Бусад орлого	м.төг	8,688,120.8	236,960.7	97,913.7	(8,590,207.0)	1.1	(139,047.0)	41.3
2	Нийт орлого	м.төг	24,970,853.5	18,705,655.3	20,189,605.1	(4,781,248.4)	80.8	1,483,949.8	107.9
3	Нийт зардал	м.төг	22,994,057.6	14,744,689.1	15,958,429.6	(7,035,627.9)	69.4	1,213,740.5	108.2
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	114,061.8	149,730.0	149,301.2	35,239.4	130.8	(428.7)	99.7
4	Татварын өмнөх ашиг	м.төг	1,976,795.9	3,960,966.2	4,231,175.4	2,254,379.5	214.0	270,209.2	106.8
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	1,131,724.8	3,235,628.3	3,363,679.1	2,231,954.2	297.2	128,050.7	103.9
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	1,157,207.2	1,174,492.6	1,255,985.1	98,777.8	108.5	81,492.5	106.9
	а/ Орлогын татварт	м.төг	845,071.1	725,337.8	867,496.3	22,425.2	102.6	142,158.5	119.6
	б/ НӨТ	м.төг	-	-	-	-	-	-	-
	в/ НДШ	м.төг	311,364.9	446,774.6	386,237.4	74,872.4	124.0	(60,537.2)	86.45
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	-	-	-	-	-	-	-
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	-	-	-	-	-	-	-
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	771.2	2,380.2	2,251.3	1,480.1	291.9	(128.8)	94.59
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	-	-	-	-	-	-	-
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	-	-	-	-	-	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	51.0	44.0	44.0	1.15	13.7	-	-
9	Нийт цалингийн сан	м.төг	2,508,338.5	3,574,197.0	3,119,996.5	611,658.0	124.3	(454,200.4)	87.2
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	4,098.5	5,135.3	4,999.9	901.4	121.9	(135.3)	97.3

Үндэсний давхар даатгал ХК -ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	1.0	1.2	1.2	0.1	116.5	(0.0)	99.7
12	Хөрөнгө оруулалт	м.төг	151,914.7	129,350.0	84,793.0	(67,121.7)	55.8	(44,556.9)	65.5
13	Нийт авлага	м.төг	1,223,966.2	-	1,454,478.2	230,512.0	118.8	1,454,478.2	-
	Үүнээс: Найдваргүй	м.төг	120,541.3	-	6,076.6	(114,464.6)	5.0	6,076.6	-
14	Нийт өглөг	м.төг	32,397,389.2	-	35,062,577.7	2,665,188.5	108.2	35,062,577.7	-
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	438,847.5	-	443,270.6	4,423.0	101.0	443,270.6	-
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	31,958,541.6	-	34,619,307.0	2,660,765.4	108.3	34,619,307.0	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Үндэсний давхар даатгал ХК (цаашид “Компани” гэх) нь эрхэм зорилгоо “Бид үйлчлүүлэгчийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй, найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, үндэсний давхар даатгалын тогтолцоог хөгжүүлнэ” гэж тодорхойлжээ.

Компани нь Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 48 дугаар тогтоолын дагуу давхар даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд Малын индексжүүлсэн даатгал (цаашид “МИД” гэх)-аас гадна гэнэтийн ослын, хөрөнгийн, ачаа тээврийн, хариуцлагын болон бусад даатгалын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Компанийн дүрэмд зааснаар өмчийг 100.0 хувь төр эзэмшдэг, төрийн өмчийн төлөөллийг Засгийн газраас эрх олгосноор Сангийн яам хэрэгжүүлэхээр заасан ба компани нь нэг бүр нь 100.00 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 245 сая ширхэг энгийн хувьцаагаарх өмч бүртгэлтэй байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Үндэсний давхар даатгал ХК нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн дагуу Засгийн газрын 2014 оны 280 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК нэртэйгээр анх байгуулагдсан бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 48 дугаар тогтоолын дагуу давхар даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг.

Гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулах, давхар даатгалын зардлыг багасгах зорилгоор Засгийн газрын 2018 оны 303 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн нэрийг Үндэсний давхар даатгал ХК болгон үйл ажиллагааг нь өргөтгөсөн байна.

Компани нь Иргэний тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.;

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Компанийн дотоод хяналтын албаны ажилтан нь анхан шатны баримтын бүрдэл, бусад хууль тогтоомжийн хүрээнд 1 удаа хяналт шалгалт хийж, 1 зөвлөмж өгч, хангалттай гэж үнэлсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд 3 хүний бүрэлдэхүүнтэй дотоод аудитын хороо ажилладаг бөгөөд тус компанийн 2025 онд төлөвлөгөөт 3, төлөвлөгөөт бус 1 дотоод аудитын хяналт хийж, дүгнэлт зөвлөмж гаргасан байна.

Дотоод аудитын чиг үүрэг түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголтыг олж авсан ба дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үндэсний давхар даатгал ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компани нь ТУЗ-ийн 2019 оны 04 тоот тогтоолоор баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, даатгалын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Үндэсний давхар даатгал ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,463.0 сая төгрөгөөр буюу 8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,630,703.4	1,332,398.4	(298,305.0)
Авлага	1,103,813.7	1,450,566.2	346,752.5
Бусад санхүүгийн хөрөнгө	57,967,999.0	62,618,443.0	4,650,444.0
Бараа материал	18,882.4	46,442.3	27,559.9
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,416,433.1	1,810,627.9	394,194.8
Биет бус хөрөнгө	5,054.1	1,263.5	(3,790.6)
Үндсэн хөрөнгө	201,788.1	547,882.5	346,094.4
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	55.1	55.1
Нийт хөрөнгийн дүн	62,344,673.8	67,807,678.9	5,463,005.1
Богино хугацаат өр төлбөр	438,847.6	443,270.7	4,423.1
Урт хугацаат өр төлбөр	12,958,541.6	15,619,307.0	2,660,765.4
Эздийн өмчийн дүн	48,947,284.6	51,745,101.2	2,797,816.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	62,344,673.8	67,807,678.9	5,463,005.1

Дээрх хүснэгтээс харахад дараах данстуудад материаллаг хэмжээний өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,332.4 сая төгрөг болж, өмнөх оноос 298.3 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгө оруулалтын өгөөж, хөрөнгө оруулалтад байршуулсан мөнгөн хөрөнгийн өссөнтэй холбоотой;
- Авлагын дансны үлдэгдэл 1,450.6 сая төгрөг болж, өмнөх оноос 346.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант жилийн эцэст хийгдсэн даатгалын гэрээнүүдийн бүртгэлтэй холбоотой;

- Бусад санхүүгийн хөрөнгө буюу хөрөнгө оруулалтын үлдэгдлийн өсөлт нь тайлант жилд Төрийн банкинд 1,300.0 сая төгрөгийн хадгаламж, Худалдаа хөгжлийн банкинд 3,550.0 сая төгрөгийн хадгаламжийг тус тус нэмж байршуулснаас голлон нөлөөлсөн;
- Урьдчилж төлсөн зардал өмнөх оноос 394.2 сая төгрөгөөр өссөн нь давхар даатгалын төлбөрийг олон улсын байгууллагад шилжүүлснээс голлон шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгийн өсөлт нь оффисын барилгыг түрээсээр эзэмшиж, тухайн хөрөнгийг 666.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн ашиглах эрхтэй хөрөнгөөр бүртгэж үндсэн хөрөнгөөр толилуулсан нь өсөлтөд голлон нөлөөлсөн;
- Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос 2,660.7 сая төгрөгөөр өссөн нь хамтын эрсдэлийн сангийн хэмжээ 778.6 сая төгрөг, нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээг 1,161.9 сая төгрөгөөр нэмэгдүүлснээс голлон нөлөөлсөн;
- Тайлант үеийн цэвэр ашгийн 3,363.6 сая төгрөгөөр эздийн өмчийн дүнг нэмэгдүүлж, ТУЗ-ын №07 дугаар тогтоолын дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 312 дугаар тогтоолоор улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг тогтоосонтой холбогдуулан 565.8 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилснаас буурсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Үндэсний давхар даатгал ХК нь эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, ТУЗ-өөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТУЗ-ын 2024 оны 12 сарын 31-ны өдрийн 24 дугаартай тогтоолоор баталсан компанийн 2025 оны үйл ажиллгааны төсөв болон бараа ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд нийт орлогыг 18,705.6 сая төгрөг, нийт зардлыг 14,744.7 сая төгрөг, 3,960.9 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тусгасан байна.

Гүйцэтгэлээр 20,189.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 15,958.4 сая төгрөгийн зардал гарган, 4,231.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 20,189.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,483.9 сая төгрөг буюу 7.9 хувиар давсан нь Хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны орлогыг 19.6 хувиар давуулан биелүүлсэнээс нөлөөлсөн.

Нийт зардлын гүйцэтгэл 15,958.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,213.7 сая төгрөг буюу 8.0 хувиар илүү гүйцэтгэлтэй гарсан нь даатгалын зардал 28.5 хувиар хэтэрсэнтэй холбоотой байна.

Тайлант онд цэвэр ашиг 3,363.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 128.0 сая төгрөгөөр илүү байгаа нь хөрөнгө оруулалтын орлогыг давуулан биелүүлсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу авсан судалгааны үр дүнгийн талаар: Үүнд,

1. Компанийн орон тооны цомхотголын талаар

ТУЗ-ийн 2024 оны 21 дүгээр тогтоолоор бүтэц орон тоог 44 ажилтнаар баталсан, тайлант онд 44 үндсэн ажилтан ажилласан байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

ТУЗ-ийн 2024 оны 24 дүгээр тогтоолоор нэг өдрийн унаа 1,000.00 төгрөг, хоолны хөнгөлөлтийг 15,000.00 төгрөгөөр баталсан. Тайлант онд 174.7 сая төгрөгийн төсөвлөснөөс гүйцэтгэлээр 125.2 сая төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлтийг зарцуулсан байна.

3. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн:

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардалд 74.4 сая төгрөгийг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 59.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

4. Гадаад томилолтын судалгааны үр дүн:

Гадаад томилолтын зардалд 202.8 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 148.6 сая төгрөгийг олон улсын давхар даатгалын компаниудын уулзалт, семинар, сургалтын арга хэмжээний хүрээнд зарцуулсан байна.

5. Хэвлэл мэдээллийн судалгааны үр дүн:

Компани нь хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг сурталчлахад 193.5 сая төгрөг, Zangia.mn сайтаар 2025 онд 3 удаа ажлын байрны зар оруулснаас 9 анкет хүлээн авч 3 хүнийг ажлын байранд шалгаруулах зардалд 0.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

6. Программ хангамжийн судалгааны үр дүн:

Тус компани үйл ажиллагаандаа Малын индексжүүлсэн даатгалын программ, Датабааз, Unicus санхүүгийн программ, компанийн нэгдсэн цогц программ хангамж, хүний нөөцийн программ програмуудыг ашигладаг бөгөөд жилийн хураамж хөгжүүлэлтийн дүнд 75.6 сая төгрөг төлсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Үндэсний давхар даатгал ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг БДО аудит ХХК-ийн аудитын менежер Н.Даваасүрэн, ахлах аудитор С.Пүрэвжал, аудиторын туслах Б.Бямбагэрэл, П.Мөрөн, Б.Тэмүлүн нар гүйцэтгэж, Партнер Д. Батсуурь, ахлах менежер Б.Ариунтунгалаг нар анхан шатны чанарын хяналтыг хийж, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Үндэсний давхар даатгал ХК нь 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар албан бичгээр ирүүлээгүй байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн даатгалын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн даатгалын орлого 11,413.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 171.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор компани нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн хариуцах НДШ болон мэргэжилтнийг ажиллуулах хөлс зэргээс 514.7 сая төгрөг, бараа үйлчилгээний болон бусад зардлаас 429.5 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд 1 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлагыг тус тус хүргүүлэв.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан нийт 142 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 8.1-д заасны дагуу нийт 17 агуулгын 142 мэдээллийг иж бүрэн байршуулсан боловч байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар гэсэн 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн Шилэн дансны зарчим 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд иж бүрэн мэдээлээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Төсвийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасны дагуу шалгагдагч байгууллага нь санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад хүргүүлсэн байх үүрэгтэй.

Компани нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 15-ний өдөр байдлаар ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж, албан үүргээ биелүүлээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгууртай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан үйл ажиллагаа болон төлөвлөх үе шатны хэсэгт компанийн үндсэн ойлголт, гадаад дотоод орчин, байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, компанийн дотоод гадаад хяналтууд зэрэгтэй танилцан эрсдэл бүрийг үнэлж тухайн эрсдэлд чиглэсэн горимыг төлөвлөсөн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа, хорогдуулга, дансны үлдэгдлийг жил бүрийн эцэст зөв үнэлж, бүртгэх, шилэн дансны цахим системд мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, хугацаанд нь байршуулж байх 2 зөвлөмж өгснийг нотлох баримттай тулган шалгахад 50 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	1	-	50%
Нийт дүн	2	-	1	-	50%

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахтай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар өөрчлөлт орсон ба шинээр гарсан стандартын заалт, үүний дотор СТОУС-17-д нийцүүлэн, НБББББ-т шинэчлэлт хийж мөрдөж ажиллаж байгаа эсэхийг үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 70.7 сая төгрөгийн зөрчил¹ илэрсэнд зөрчлийн дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 70.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 100.5 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулгатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нөхөн төлбөрийн мэдээллийг мэдээллийн баазад үнэн зөв бүртгэхэд хангалттай хяналт тавьж ажиллаагүй, үүнтэй холбоотойгоор компанийн актуар тооцоололд ашигласан мэдээлэл нь үнэн зөв бус байна.

Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны 66 тоот тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн хавсралт 8-ын 3.1.9-д заасан “Даатгалын хураамж, нөөц сангийн тооцоололтой холбоотой статистик мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн баазын баяжуулалтын үнэн зөв байдалд хяналт тавих” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

1. Даатгалын гэрээний бүртгэлтэй холбоотой НБББББ-ийг СТОУС 17-д нийцсэн байдлаар сайжруулах шаардлагатай. Ингэхдээ даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлтийн аргууд болох ерөнхий аргачлал болон хураамжийн хуваарилалтын аргыг ашиглах нөхцөлүүдийг тодорхой тусгах.
2. Мөн тэдгээр аргачлалын дагуу хүлээн зөвшөөрөх үед хэмжилтийг гүйцэтгэхэд шаардлагатай ирээдүйн мөнгөн урсгалын тооцоо, санхүүгийн бус эрсдэлийн тохируулга, хөнгөлөлтийн хувь болон хугацааны үнэ цэнэ, гэрээний үйлчилгээний маржин, хамрах нэгжүүд болон алдагдалтай гэрээнүүдтэй холбоотой тодорхойлолт, тэдгээрийг тодорхойлох аргачлалын талаар тодорхой тусган, даган мөрдөлтөд хяналт тавьж ажиллах.

2. Нөөц сангийн тооцоололтой холбоотой асуудал

Илрүүлэлт:

СТОУС 17 стандартын дагуу даатгалын гэрээний орлогыг хоёр өөр аргыг ашиглан хүлээн зөвшөөрч болно. СТОУС 17 нь Урт хугацаат даатгалын гэрээнүүдийг Ерөнхий аргачлалаар хэмжихийг шаарддаг ба шалгагдагч байгууллага нь бүх даатгалын гэрээг шимтгэлийн хуваарилалтын аргыг ашиглан хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт" гэж заасны хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

1. Даатгалын тохиолдлын бүртгэл, түүний шийдвэрлэлтийн бүртгэлд хяналт хийх дотоод хяналтыг бий болгон бүртгэгдсэн даатгалын тохиолдлын статуст өөрчлөлт орсон болон даатгалын тохиолдолтой холбоотой нэмэлт мэдээлэл ирсэн тухай бүр бүртгэлд тусгаж байх, хэрвээ тухайн даатгалын тохиолдолтой холбоотой нөхөн төлбөрийг нэхэмжлэх хугацаа өнгөрсөн тухай бүрд нь даатгалын тохиолдлын статуст өөрчлөлт оруулж байх.
2. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 сарын 25-ны 66 тоот тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн хавсралт 8 “Актуарын үйл ажиллагааны журам”-ын 3.4-т “Тооцоололд ашигласан тоон мэдээлэл гэдэгт актуарчийн авч ашигласан өгөгдөхүүнд итгэж болох байдал, хамрах хугацаа, мэдээллийн бодит эх сурвалж, мэдээллийн харьцуулалтын тухай бичнэ” гэснийг баримтлан тооцоололд ямар хугацааны мэдээллийг ашигласан талаарх мэдээллийг тодорхой тусгаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СТОУС 17 стандартын дагуу даатгалын гэрээний орлогыг хоёр өөр аргыг ашиглан хүлээн зөвшөөрч болно. СТОУС 17 нь Урт хугацаат даатгалын гэрээнүүдийг Ерөнхий аргачлалаар хэмжихийг шаарддаг ба шалгагдагч байгууллага нь бүх даатгалын гэрээг шимтгэлийн хуваарилалтын аргыг ашиглан хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	1	70,773.3	-	-	-	-	1	70,773.3	-	-	-	-
Нөхөн төлбөрийн мэдээллийг мэдээллийн баазад үнэн зөв бүртгэхэд хангалттай хяналт тавьж ажиллаагүй, үүнтэй холбоотойгоор компанийн актуар тооцоололд ашигласан мэдээлэл нь үнэн зөв бус байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	2	70,773.3	-	-	-	-	2	70,773.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 8.1-д заасны дагуу нийт 17 агуулгын 142 мэдээллийг иж бүрэн байршуулсан боловч байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар гэсэн 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна	1	-	-	-	1	-	-	-
Компани нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 15-ний өдөр байдлаар ирүүлээгүй байна.	-	-	-	-	-	-	1	-
Дүн	2	-	-	-	1	-	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 893/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/73/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний Давхар Даатгал ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 8.1-д заасны дагуу нийт 17 агуулгын 142 мэдээллийг иж бүрэн байршуулсан боловч байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар гэсэн 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн Шилэн дансны зарчим 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд иж бүрэн мэдээлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний Давхар Даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Жавхланта), Бүртгэл санхүү, төлөвлөлтийн газрын дарга (Ч.Соронзонболд) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БДО АУДИТ ХХК-ИЙН
АУДИТЫН ПАРТНЕР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Д.БАТСУУРЬ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 894/А0150067

Улаанбаатар хот

САГ-2026/73/НА-СТА-ТӨҮГ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний Давхар Даатгал ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компани нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 15-ний өдрийн байдлаар ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж, албан үүргээ биелүүлээгүй Ерөнхий нягтлан бодогч Г.Гэрэлт-Од-д сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Жавхлантай/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БДО АУДИТ ХХК-ИЙН
АУДИТЫН ПАРТНЕР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Д.БАТСУУРЬ